

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ СУРГУУЛИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВЧ, ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Боловсруулсан:

ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль

Хянасан:

**ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын
зөвлөл**

Дэмжсэн:

ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах багш нарын зөвлөл

Баталсан:

ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирал



ШУТИС-ийн харьцаа төрөхий боловсролын ахлах
сургуулийн захирлын 115 оны 1/сарын 01-д өдрийн 10/10/19
дугаар тушаалын зургаадугаар хавсралт

АГУУЛГА

АГУУЛГА.....	2
Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ.....	3
ТАВ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ	4
ЗУРГАА. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ, ТАЙЛАГНАХ.....	5



ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын // бодын // сарын 01 өдрийн 2024 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү дүрмийн эрхэм зорилго нь ШУТИС-н харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль /цаашид “сургууль” гэх/-н багш, ажилтан, гэрээгээр ажил гүйцэтгэж буй бусад байгууллагын ажилтан, орон тооны бус зөвлөлүүдийн гишүүн /цаашид багш, ажилтан гэх/ нь сургалт, эрдэм шинжилгээ болон нийгэмд үзүүлэх үйлчилгээ, хүний эрх, эрх чөлөө, үнэ цэн, тэдгээрийг хүндэтгэх үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх үндсэн чиг үүргээ хариуцлагатай биелүүлэх болон ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Багш, ажилтны нийгэм, сургууль, хамт олонтой хамтран ажиллах болон хүлээх хариуцлага, эдлэх эрх чөлөө, эзлэх байр суурийн харилцан уялдаа холбоог зохицуулах нь энэхүү дүрмийн үндэс юм.
- 1.3. Багш, ажилтан нь төрийн албан хаагчийн ёс зүйн талаар эрх бүхий байгууллагаас баталсан хууль, тогтоомж энэхүү дүрэмд заасан мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдеж ажиллана.
- 1.4. Сургуулийн Багш, ажилтны ёс зүйн дэд хороо /цаашид “Хороо”/ сургуулийн хэмжээнд багш, ажилтны ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээний асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл юм.
- 1.5. Сургууль нь энэхүү багш, ажилтны ёс зүйн дүрмийг Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэмд нийцүүлэн гаргасан болно.
- 1.6. Энэхүү журмаар зохицуулагдаагүй асуудлыг сургуулийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Энэхүү дүрэм нь ШУТИС-н харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн багш, ажилтан, гэрээгээр ажил гүйцэтгэж буй бусад байгууллагын ажилтан, орон тооны бус зөвлөлүүдийн гишүүнд хамаарах ёс зүйн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх болон ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулна.

ГУРАВ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1. **Боловсролын байгууллагын ёс зүйн хэм хэмжээ:** Сургуулийн сонирхогч талууд тэгш эрхтэйгээр харилцаж, сонирхлын зөрчлөөс зайлсхийж, нийгмийн ашиг тусын тулд үйл ажиллагаа явуулах ёс зүйн мэргэжлийн орчныг бий болгох чадвар
- 3.2. **Орон тооны бус зөвлөлүүдийн гишүүн:** Сургуулийн зөвлөл бусад тушаал шийдвэрээр бий болсон зөвлөлүүд
- 3.3. **Ялгаварлан гадуурхалт:** Аливаа хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин



- шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхах үзэл
- 3.4. **Эрх тэгш хандах:** Нас, хүйс, арьсны өнгө, нийгэм, эдийн засгийн байдал эсвэл бусад ялгараах шинж чанар, ялгаатай байдлаас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхах, давуу эрх олгохгүйгээр хуулийн өмнө хүн бүрд ижил тэгш хандах
- 3.5. **Хүчирхийлэл:** Эрх бүхий этгээд эрх мэдэл, албан тушаалын хүрээнд бусдад бие болон сэтгэл зүйн дарамт, шахалт, сүрдүүлэг, зэрэг хуулиар хориглосон болон мэргэжлийн ёс зүйд үл нийцэх үйлдэл, эс үйлдэхүй
- 3.6. **Дарамт:** Бусдыг хүсээгүй байхад үг хэлээр, биеэр болон өөр бусад хэлбэрээр ажил, албан тушаал, эд материал, бие махбод, сэтгэл санаа, бэлгийн болон бусад байдлаар хохироо үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх
- 3.7. **Ёс зүйн зөрчил:** Сургуулийн багш, ажилтны ёс зүйн дүрэмд тусгасан ёс зүйн үүрэг болгосон, хориглосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй
- 3.8. **Ёс зүйн зөрчил гаргагч:** Сургуулийн багш, ажилтны ёс зүйн дүрэмд заасан ёс зүйн үүрэг болгосон, хориглосон хэм хэмжээг зөрчсөн нь ёс зүйн дэд хороогоор тогтоогдсон багш, ажилтан
- 3.9. **Био ёс зүй:** Хүнийг шууд ба шууд бус оролцуулан хийх шинжлэх ухааны тодорхой чиглэлийн судалгаанд баримтлах хэм хэмжээ
- 3.10. **Цахим ёс зүй:** Цахим болон цахим хэрэгсэл болох интернэт, ухаалаг утас, төрөл бүрийн программ хангамж, нийгмийн сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдийн бие даасан байдал, нэр төрийг хүндэтгэх зорилготой хэм хэмжээ

ДӨРӨВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 4.1. Сургуулийн багш, ажилтны ёс зүйн дэд хороо
- 4.1.1 Сургуулийн хэмжээнд багш, ажилтны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг шийдвэрлэх
- 4.1.2 Сургуулийн хэмжээнд ёс зүйн дүрмийг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах
- 4.1.3 Багш, ажилтныг буруугүй гэж үзвэл түүний эрх ашиг, нэр хүндийг хамгаалах, сэргээх
- 4.1.4 Ёс зүйн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргах
- 4.1.5 Ёс зүйн хэм хэмжээний талаар сургалт, сурталчилгааг төлөвлөх, хэрэгжүүлэх
- 4.2. Ёс зүйн дэд хорооны дарга
- 4.2.1 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг удирдлагаар хангах
- 4.2.2 Ёс зүйн дэд хорооны гишүүдийн баримтлах зарчмыг мөрдүүлж, ажиллах
- 4.2.3 Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, биелэлтэд хяналт тавих
- 4.2.4 Гишүүдийн ажил үүргийн хуваарь гаргах, батлах
- 4.2.5 Ёс зүйн дэд хорооны хурал зарлан хуралдуулах
- 4.2.6 Ёс зүйн дэд хорооны шийдвэрийг үндэслэн дүгнэлт гаргах
- 4.2.7 Ёс зүйн дэд хорооны хурлаас гаргасан санал, дүгнэлтийг холбогдох материалын хамт эрх бүхий албан тушаалтанд уламжилж шийдвэрлүүлэх
- 4.3. Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
- 4.3.1 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл боловсруулах
- 4.3.2 Хурлын бэлтгэл хангах, тов зарлах
- 4.3.3 Хурлын тэмдэглэл хөтлөх
- 4.3.4 Ёс зүйн дэд хорооны ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэх
- 4.3.5 Багш, ажилтны ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдлыг судалж, хэлэлцүүлэх



ШУТИС-ийн харьяа өрөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын түүрүүсээр өдрийн 2009 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

- 4.3.6 Өргөдөл, гомдол гаргагч болон хариуцлага хүлээгч, холбогдох, байгууллагуудад гаргасан шийдвэрийг бичгээр хүргүүлэх
- 4.3.7 Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, гомдол гаргагчид мэдээлэх, бүртгэх
- 4.3.8 Ёс зүйн дэд хорооны мэдээ, тайланг гаргаж, албан хэрэг хөтлөх
- 4.4. Гомдол гаргагч
 - 4.4.1 Ёс зүйн зөрчилтэй холбогдох өргөдөл, гомдлыг бичиж, өөрийн биеэр ёс зүйн зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгөх
 - 4.4.2 Өргөдлийн хариуг тогтоосон хугацаанд шаардах
 - 4.4.3 Өргөдөл гаргагч ёс зүйн дэд хорооны шийдвэртэй санал нийцэхгүй бол дараагийн шатны нэгжид хандах эрхтэй
- 4.5. Харьяалах нэгжийн дээд удирдлагад холбогдох багш, ажилтантай холбоотой ёс зүйн өргөдөл, гомдлыг шууд гарган, шийдвэрлүүлж болно.
- 4.6. Ахлах сургуулийн суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах гэрээний заалтыг чанд мөрдөх

ТАВ. ҮНЭТ ЗҮЙЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 5.1. Багш, ажилтан нь албан үүргээ гүйцэтгэхдээ дараах үнэт зүйлсийг эрхэмлэнэ.
 - 5.1.1 Суралцагчийн эрх, аюулгүй байдал, нэр хүнд
 - 5.1.2 Төрийн албан хаагчийн болон багш мэргэжлийн нэр хүнд
 - 5.1.3 Аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид эрх тэгш, хүндэтгэлтэй, эерэг харилцаа;
 - 5.1.4 Багшийг хүндлэн дээдлэх олон нийтийн итгэл үнэмшил
- 5.2. Хуулиар олгогдсон эрхээ эдлэх, хэрэгжүүлэхдээ бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэнэ.
- 5.3. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх суурь эрх чөлөөг хүндэтгэнэ.
- 5.4. Мэдлэг олгох, сурч боловсрох эрх ашгийг урьтал болгох, судалгааны ажлын эрх чөлөөг хүндэтгэх, мэргэжлийн үнэ цэнийг хамгаалахыг эрмэлзэнэ.
- 5.5. Нийгмийн хариуцлагыг ухамсарлан хүн бүрд хүртээмжтэй, аюулгүй, эрүүл таатай орчинд ажиллах, суралцах боломж олгоно.
- 5.6. Суралцагч болон хамт олонд итгэм үнэмшил, шашин шүтлэг, улс төрийн болон нийгмийн байр суурийн талаарх хувийн үзэл бодлоо шууд болон шууд бусаар тулган хүлээлгэхгүй, нөлөөлөхгүй байна.
- 5.7. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн баримтлах зарчим:
 - 5.7.1 Ёс зүйн дэд хорооны хурал дээр хэлэлцсэн асуудал болон ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг нууцлах
 - 5.7.2 Аливаа асуудалд эрх тэгш, шударга хандах
 - 5.7.3 Хэлэлцэж буй асуудалд хувийн ашиг сонирхлоор хандахгүй байх

ЗУРГАА. ҮҮРЭГ БОЛГОСОН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

- 6.1 Багш ажилтны дагаж мөрдөх мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг дор дурдсанаар ангилна.
 - 6.1.1 Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ;
 - 6.1.2 Ажил, мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ;
 - 6.1.3 Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээ;



ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах
сургуулийн захирлын №¹ оны №¹ өдрийн №¹
дугаар тушаалын гуравдугаар хөвсрэлтэй

- 6.1.4 Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ.
- 6.2 Суралцагчийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:
- 6.2.1 Боловсролын үйлчилгээ үзүүлэхдээ суралцагч бүрийн эрх, нэр төр, үндэс угсаа, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэнд, танин мэдэхүйн онцлог, ялгаатай байдал, нийгмийн байдал, суралцах чадвараар ялгаварлан гадуурхахгүй, соёлын олон талт байдалд хүндэтгэлтэй, тэгш хандах;
 - 6.2.2 Суралцагчид бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт үзүүлэх, хүчээр албадахаас татгалзах;
 - 6.2.3 Хичээл сургалтын үйл ажиллагааны явцад олж авсан суралцагчийн болон түүний гэр бүлийн нууцыг ажил эрхлэх хугацаанд болон хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсноос хойш бүхий л хугацаанд чандлан хадгалах, мэдээлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллага, эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрсний дагуу мэдээлэх;
 - 6.2.4 Ажил үүргээ гүйцэтгэсний төлөө суралцагчаас шан харамж, бэлэг, авлига авах, бусдад зуучлах, хуульд заагаагүй төлбөр, хураамж, хандив, тоног төхөөрөмж, эд материал өгөхийг шаардах, ном, сургалтын хэрэглэгдэхүүн, бусад зүйлийг тулган борлуулахаас татгалзах;
 - 6.2.5 Сургалтын орчинд хүүхдийн эрх зөрчигдөх, эрүүл мэнд хохирох, дарамт, ялгаварлан гадуурхалд өртөх, серөг нөлөөнд автхааас урьдчилан сэргийлэх;
 - 6.2.6 Суралцагчид мэдлэг, чадвар, хандлага, харилцаа, хувцаслалт, биеэ авч явах байдал, арга барилаар зөв үлгэрлэх;
 - 6.2.7 Суралцагчийн өмнө зүй бус үг хэллэг, үйлдэл гаргах, хууль, дүрэм журам, ёс зүйн хэм хэмжээ зөрчихеөс сэргийлэх;
 - 6.2.8 Сургалтын агуулга, хөтөлбөрт зааснаас бусад тохиолдолд улс төр, цэрэг дайн, шашин, нийгмийг хамарсан өвчин тахал болон бусад асуудлаар хүүхдийг айдаст автуулахуйц эх сурвалжгүй мэдээлэл хийх, хувийн үзэл бодлоо тулгахаас зайлсхийх;
- 6.3 Ажил, мэргэжлийнхээ өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээний хүрээнд
- 6.3.1 Ажил, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, хууль тогтоомж, дүрэм журам, бусад эрх зүйн баримт бичгийг судалж мэдэх, хувийн үзэл бодлоос үл хамааран дагаж мөрдөх;
 - 6.3.2 Өөрийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын гүйцэтгэлийг шударга, бодитой үнэлэх;
 - 6.3.3 Ажлын байр, олон нийтийн газар болон цахим орчинд бусадтай харилцахдаа ажил, мэргэжлийнхээ нэр хүндэд харшлах аливаа үйл ажиллагаа, үг, үйлдэл, эс үйлдэхүйгээс татгалзах;
 - 6.3.4 Хичээл сургалтын явцад, сургалтын орчинд хууль бус үйл ажиллагаа, жагсаал цуглаан, шашны зан үйл зохион байгуулах, оролцох, бусдыг оролцохыг тулган шаардах, суралцагчийг татан оролцуулахаас татгалзах;
 - 6.3.5 Ажил эрхлэх, албан тушаал дэвшихдээ боловсролын түвшин, мэргэжлийн ур чадвараа үнэн зөв мэдүүлэх, баримт бичгээр нотлох;
 - 6.3.6 Албан байгууллагын нэр, албан тушаалын бүрэн эрхийг хувийн зорилгоор ашиглахаас татгалзах;
 - 6.3.7 Ажлын алдаа дутагдлын талаарх шударга, үнэн бодит шүүмжлэлд хүндэтгэлтэй хандах, алдаа дутагдлаа засах, сайжруулах хандлага, чадвартай байх;



ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын масны дасын өдрийн дугаар тушаалын гуравдугаар хавсралт

- 6.3.8 Багш, ажилтан нь өөрийн буруутай үйлдэл эс үйлдэхийн төлөө ёс зүйн хариуцлага хүлээх чадвартай байх.
- 6.4 Хамт олон, хамтран ажиллагч, олон нийтийн өмнө хүлээх ёс зүйн хэм хэмжээний хүрээнд
- 6.4.1 Боловсролын харилцаанд оролцогч багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, иргэн, үйлчлүүлэгчийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, эрхэлдэг ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохгүй байх;
- 6.4.2 Хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх, саналын зөрүүтэй тохиолдолд бусдад хүндэтгэлтэй хандах, зөрчилдөөнийг зөргээр шийдвэрлэхэд мэргэжлийн ур чадвар, манлайлал үзүүлэх;
- 6.4.3 Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны явцад үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний эрх, нэр төрийг хүндэтгэх, тэдэнд учирч болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх;
- 6.4.4 Ажил үүргээ гүйцэтгэсний төлөө бусдаас аливаа урамшуулал, бэлэг, шан харамж шууд болон шууд бусаар авах болон бусдад зуучлахаас татгалзах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлээс сэргийлэх;
- 6.4.5 Зүй бүс үг, үйлдэл, зан байдлаараа албан харилцааны хэвийн байдал, хамт олны эв нэгдэл, уур амьсгалыг алдагдуулах, бусдыг хууль бус үйл ажиллагаанд уриалах, турхирахыг цээрлэх;
- 6.4.6 Ажлын байранд архидан согтуурах, бусдыг дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох, ажлын байрны болон бэлгийн дарамт шахалт үзүүлэхээс цээрлэх;
- 6.4.7 Багш, ажилтан нь гүйцэтгэлийн үнэлгээ болон бусад шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд оролцохдоо шударга байх, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй бол татгалзах;
- 6.4.8 Өөрийн мэдлэг, чадвар, туршлага, ажил хэргийн мэдээ, мэдээллийг хамтран ажиллагчтай хуваалцахаас үл татгалзах;
- 6.4.9 Албан үүргээ гүйцэтгэхэд нь бусдад саад учруулах, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхгүй байх;
- 6.4.10 Удирдах, удирдуулах зарчмыг баримталж, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтнаас баталсан шийдвэр, хууль ёсны үүрэг даалгавар, шаардлагыг хэрэгжүүлэхээс үл татгалзах;
- 6.4.11 Албан тушаалын бүрэн эрх, давуу байдлаа ашиглан багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид хууль бус шаардлага, үүрэг даалгавар өгөхгүй, шийдвэр гаргахгүй байх, хууль бус үүрэг, шийдвэрийг үл биелүүлээгүйн төлөө хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй, дарамт шахалт үзүүлэхгүй байх;
- 6.5 Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээний хүрээнд
- 6.5.1 Багш, ажилтан нь суралцагч, хамт олон, эцэг, эх асран хамгаалагч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай нийгмийн сүлжээ, технологиор дамжуулан боловсролын аливаа харилцаанд оролцохдоо энэ дүрмийн 4.2, 4.3, 4.4-д заасан ёс зүйн хэм хэмжээг баримтлах;

- 6.5.2 Багш, ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ байгууллагаас зөвшөөрсэн албаны цахим шуудангийн хаягийг ашиглах, албан хэрэгтээ хувийн цахим хаягийг ашиглахаас татгалзах;
- 6.5.3 Нийгмийн сүлжээнд үзэл бодол, хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэхдээ ажил, мэргэжлийнхээ нэр хүндийг дээдлэн, багш, суралцагчад буруу үлгэр дуурайл үзүүлэхээс зайлсхийх, эх сурвалж нь тодорхой бус мэдээ, мэдээлэл түгээхээс урьдчилан сэргийлэх;
- 6.5.4 Технологийн дэвшилийн талаар зохих мэдлэгтэй, зүй зохистой хэрэглээтэй байх;
- 6.5.5 Цахим технологи ашиглан боловсруулсан багш, ажилтан, суралцагчийн мэдээлэл, бүртгэл, боловсролын баримт бичгийн нууцлалыг хангах, хамгаалах;
- 6.5.6 Технологи ашиглан хууль бус үйл ажиллагаанд оролцох, бусдын нууцыг задруулахаас урьдчилан сэргийлэх;
- 6.5.7 Цахим хичээл, контент бүтээх, ашиглахдаа оюуны өмчийн хууль тогтоомжийн зөрчил гаргахгүй байх;
- 6.5.8 Эцэг, эх, асран хамгаалагч, багш, ажилтан, суралцагчийн зөвшөөрөлгүйгээр тэдний зураг, бичлэгийг нийгмийн сүлжээнд нийтлэх болон ажил хэргийн зорилгоор авсан зураг, бичлэгийг хувийн ашиг сонирхол, бусдын нэр хүндэд халдах зорилгоор ашиглахыг цээрлэх;
- 6.5.9 Албан хэрэгцээний эд хогшил, тоног төхөөрөмж, цахим хэрэглэгдэхүүнийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;

ДОЛОО. ЁС ЗҮЙН ХОРИГЛОХ ХЭМ, ХЭМЖЭЭ

7.1 Нийтлэг хориглосон хэм хэмжээ

- 7.1.1 Хувийн ашиг сонирхлын нөхцөл байдал үүсгэх, ямар нэгэн санал тавих, мэдээлэл сурталчилгаа хийх, зөвшөөрөл олгох, шийдвэр гаргах
- 7.1.2 Ажил горилогчийг ажилд авах, албан тушаалд дэвшүүлэх, ажилд томилох, шагнал урамшуулалд тодорхойлох, мэргэжил дээшлүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил гаргах, ил тод байдлыг үл хангах, илт давуу боломж олгох, боловсрол болон бусад тавигдсан шалгуурт нийцэхгүй хүнийг ажилд ороход нь туслах, туслахыг хүсэх, шаардах
- 7.1.3 Мэргэжлийн эсхүл шинжээчийн байр сууринаас олон нийтэд сургуулийн ажилтны нэрийг ашиглаж хандах тохиолдолд хувийн бодол, үнэлэлт, дүгнэлт гэдгээ үл онцлох
- 7.1.4 Урьдчилан зохих зөвшөөрөл авалгүйгээр сургуулийн нэр ашиглан бараа, бүтээгдэхүүний реклам, сурталчилгаа хийх
- 7.1.5 Албан тушаал, ажил гүйцэтгэх шалгаруултад өрсөлдөж байгаа хүний мэдлэг чадварын талаар санаатай худал мэдээлэл тараах
- 7.1.6 Хувийн үзэл бодлоо санаатайгаар сургууль, түүний нэгжийн байр суурь хэмээн ойлгуулах
- 7.1.7 Бусдыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн онцлог болон хувийн шалтгаанаар ялгavarлан гадуурхах, тэгш бус хандах
- 7.1.8 Сургууль, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй болгох



ШУТИС-ийн харьяа өрөнхий боловсролын ахлах
сургуулийн захирлын Мэдээллийн Усарын Өдрийн Ажлын
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

- 7.1.9 Сургууль, хамт олны эрх ашигт харшлах шийдвэр гаргах
- 7.1.10 Аливаа, тендер сонгон шалгаруулалт, худалдах, худалдан авах боловсон хүчнийг сонгох, тушаал дэвшүүлэх зэрэгт өөрийн хамаатан садан, хувийн ойр дотно харилцаатай нایз нөхдийг дэмжих, хувийн ашиг сонирхлын зөрчил гаргах, ялгаварлан гадуурхах
- 7.1.11 Хувийн ашиг сонирхолд нийцүүлэн доод тушаалын ажилтан болон суралцагчийн хөдөлмөрийг завших
- 7.1.12 Хувь хүний нэр төр, алдар хүндийг унагаах үйлдлийг байгууллага, олон нийтэд мэдээлэх, тараах
- 7.1.13 Шударга бусаар бусдын нэр төр, байр суурийг гутааж албан тушаал, мэргэжлийн салбарт ахиж дэвших боломжийг хаах, саад учруулах
- 7.1.14 Сургалт судалгааны ажлын хүрээнд улс төржих, үзэл суртал, эрх мэдэл, албан тушаалын сууринаас хандах
- 7.2 Сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон
- 7.2.1 Суралцагчтай ажиллах, дүгнэлт өгөхдөө ялгаварлан гадуурхах, тэгш бус хандах
- 7.2.2 Албан тушаал, эрх мэдлээ ашиглан суралцагчийн санал бодол, ухамсарт хүчээр нөлөөлөх, үзэл бодлоо тулгах, айлан сүрдүүлэх зөргээр зүй бус авирлах
- 7.2.3 Суралцагчийн бие махбодод халдах, сэтгэл санааны дарамт учруулах
- 7.2.4 Суралцагчаас мөнгө нэхэх, ном бүтээгдэхүүн худалдаж авахыг тулгах, хуульд заагаагүй төлбөр, хураамж авах, ном худалдан авсан тохиолдолд давуу нөхцөл үүсгэх
- 7.2.5 Суралцагчийн хувийн нууцыг задруулах
- 7.2.6 Суралцагчийн өөрийн эрх ашиг, сонирхлын үүднээс ажиллуулах
- 7.2.7 Хичээл дээр улс төр, шашны ухуулга, бусад төрлийн сурталчилгаа хийх
- 7.2.8 Шалгалтын материалыг зориуд болон санамсаргүйгээр задлах, давуу эрх олгож шалгалтын хариуг зориуд мэдээлэх
- 7.2.9 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр суралцагчдад хичээл заахаас татгалзах, хичээлд оруулахгүй байх
- 7.2.10 Сургуулиас санаачилсан, зохион байгуулсан ажил, үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулах
- 7.2.11 Сургуулийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр хувийн болон арилжаа, улс төр, шашны зорилгоор ашиглах
- 7.2.12 Бусдыг үүргээт ажлаа гүйцэтгэхэд нь саад учруулах, заналхийлэх, дарамтлах
- 7.2.13 Хамт олны мэргэжлийн болон хувийн зан чанарын талаар суралцагчидтай болон тэдний дэргэд ярилцах
- 7.2.14 Бусдын ажил үүргээ гүйцэтгэх явцад хөндлөнгөөс нөлөөлж, өөрийн үзэл бодлоо тулгах, суралцагчийн үнэлгээг заах

ШУТИС-ийн харьяа өрөнхий боловсролын ахлах
сургуулийн захирлын оны .. сарын өдрийн
дугаар тушаалын гуравдугаар хавсралт